Үйлдвэрлэлийн ослын улмаас хувь хүний эрүүл мэнд, эдийн засагт учруулах дарамтыг судлах нь

С.Марал[1,2], С.Мягмарчулуун[2], Ю.Гантөгс[2]

[1]АШУҮИС, НЭМС, Орчин ба Хөдөлмөрийн эрүүл мэндийн магистрант
[2]ХАБЭА сургалт, ISO зөвлөгөө OSHMI
Цахим шуудан: marals0716@gmail.com, Утас: 99198589

Түлхүүр үг:

Үйлдвэрлэлийн осол
Хөдөлмөрийн аюулгүй байдал
Хөдөлмөрийн чадвар алдалт
Амьдралын алдсан жил

Товч утга:

Үндэслэл: Ажлын байрны нөхцөл, үйлдвэрлэлийн орчин, хортой аюултай хүчин зүйлсийг илрүүлж хяналтандаа авч чадахгүйгээс буюу байгуулагын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо нь аль нэг хэсэгтээ алдаатайгаас үүдэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол жилээс жилд нэмэгдсээр байна[1]. **Зорилго:** Үйлдвэрлэлийн ослоос үүдэн хөдөлмөрийн чадвараа алдсан хувь хүний эрүүл мэнд, эдийн засагт учрах дарамтыг судлахад оршино. **Арга, аргачлал:** Үйлдвэрлэлийн ослын улмаас нэг буюу хоёр нүд хараагаа алдсан, харааны чадал 0.05 буюу түүнээс доош алдсан, аль нэг мөч тайрагдсан гэмтэл авсан мөн мэдрэлийн эмгэгтэй болсон хөдөлмөрийн чадвар алдалтын 50%-100% хувь хэмжээгээр тогтоолгосон нийт 30 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийж судалгааны мэдээ мэдээллийг цуглуулсан. **Үр дүн:** Үйлдвэрлэлийн осолд өртсөн 30 тохиолдлын 90% нь тухайн ажилтны амьдралын чанар дордсон, нийгмийн статус доошилсон байна. Сарын орлогын хувь 2-3 дахин буурч амьдралын чанар муудсан байна. Одоо ажил эрхлэх хүсэлтэй ч ажилд авахгүй байна гэсэн тохиолдол 80% байна. Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэлийн осолд өртсөн тохиолдлуудын дийлэнх нь хууль эрх зүйн мэдлэггүйгээс хуулийн дагуу нөхөн төлбөрийг авч чадаагүй, байгууллага хөдөлмөрийн чадварт нь тохирсон ажлын байр санал болгоогүй, нэг удаагийн нөхөн төлбөрөө олгосноос хойш дахин дэмжлэг үзүүлдэггүй, удирдлагатай холбоо харилцаа тогтоогоогүй, хамт олонгүй болсон байна. **Дүгнэлт:** Үйлдвэрлэлийн осол нь зөвхөн эдийн засагт хохирол учруулаад зогсохгүй ажилтны хувийн амьдрал, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн осол өртсөн хүмүүс хөдөлмөрийн чадвартаа тохирсон ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, орлогогүй болоод зогсохгүй, хамт олон, гэр бүл, нийгэмд гадуурхагдаж сэтгэл зүйн маш их хохирол амсаж байна.

Үндэслэл: Монгол улсын хувьд сүүлийн 10 жилд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 3802 хүн өртөж, 1055 хүн нас барсан байна[2]. Нийт бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 2016, 2017 онуудад тус бүр 332 тохиолдол бүртгэгдэж байсан бол 2018 онд 283, 2019 онд 336, 2020 онд 353, 2021 онд 256 болсон буурсан мэт боловч цаг үеийн нөхцөл байдлаас олон газрууд үйл ажиллагаа хязгаардлагдмал байснаас шалтгаалсан байх талтай тул үйлдвэрлэлийн осол ерөнхийдөө жилээс жил өсөх хандлага ажиглагдаж байна. 2016-2021 оны хооронд 6 жилийн хугацаанд гарсан нийт 1283 үйлдвэрлэлийн осол хурц хордлого бүртгэгдсэн бөгөөд үйл ажиллагааны салбараар эзлэх хувийг авч үзвэл: уул уурхай, олборлолт 376 тохиолдол буюу 29.3%; боловсруулах үйлдвэр 211 тохиолдол буюу 16.4%, барилга 155 тохиолдол буюу 12%; тээвэр болон агуулахын үйл ажиллагаа 165 тохиолдол буюу 13% тус тус эзэлж байгаа бөгөөд жил бүр өсөлттэй байгаа нь статистикаас харагдаж байна[3]. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуу болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 4.4 мянган иргэнд нийт 26.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний

улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.6 тэрбум төгрөг зарцуулсан байна[4]. ХНХЯ, SICA судалгааны байгууллагаас 2020 онд "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл" судалгааг хийсэн. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөллийн судалгааны үр дүнд үйлдвэрлэлийн осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтан, албан хаагчид цалингийн алдагдал, ажилтан, түүний гэр бүлд гарах эмчилгээний зардал, сэтгэл санааны хохирол, захиргаа, хууль эрхзүйн зардал багтана гэж үзсэн байна[5].

Үйлдвэрийн ослын улмаас биеийн хэсгүүдэд дараах байдлаар гэмтэл зонхилон тохиолддог байна. Үүнд: 34.8% нуруу, 29.5% толгой, хүзүү, 22.7% доод, дээд мөч, 7.2% цээж, бусад 5.8 % гэмтэл зонхилон тохиолддог байна[6]. Ослоос үүдэж гарах хохирол, зардлыг тооцох, гадаад орны туршлагыг судлах, ослоос урьдчилан сэргийлэх хяналтын механизмуудыг бий болгох, үйлдвэрлэлийн ослын шалтгаанд дүн шинжилгээ хийх, хувь хүн сэтгэлзүй, хохирсон эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, хүртээмж болон бусад тооцогддоггүй нэмэлт зардалыг тооцдоггүй нь энэ судалгааг хийх шаардлага болж байна.

Зорилго: Үйлдвэрлэлийн ослоос үүдэн хөдөлмөрийн чадвараа алдсан хувь хүний эрүүл мэнд, эдийн засагт учрах дарамтыг судлах

Арга, аргачлал: Судалгааг чанарын судалгааны аргыг ашиглан хийж гүйцэтгэсэн бөгөөд ингэхдээ ОУ-ын өвчний ангиллаар H54 Сохор ба хараа муудах оноштой (n=12), S49 Гэмтлийн улмаас мөр ба бугалга тайрагдах (n=1), S68 Гэмтлийн улмаас бугуй ба сарвуу тайрагдах (n=4), S68.2 Гэмтлийн улмаас гарын хоёр ба тvvнээс олон хуруу (хагас, бүтэн) тайрагдах (n=2), S53 Тохойн үе ба холбоос мултрах, сунах ба чинэрэх (n=1), S72 Дунд чөмөг хугарах (n=2), S14 Хүзүүний тувшинд нугас ба мэдрэл гэмтэх (n=1), G56 Дээд мөчний мононевропати (n=2), H90 Дуу дамжуулах ба хүлээн авах хэлбэрийн сонсгол бууралт (n=1), T23 Бугуй ба сарвуу халууны ба химийн үйлчлэлээр түлэгдэх (n=1), T32 Биеийн гадаргын гэмтлийн хэмжээгээр ангилсан халууны үйлчлэлийн түлэгдэл (n=1), S02 Гавлын ба нүүрний ясны хугарал (n=1), үе барьцалдах (n=1) буюу нийт 30 хүнтэй ганцааарчилсан ярилцлага хийж судалгааны мэдээ мэдээллийг цуглуулсан. Судалгааг чанарын судалгааны ганцааарчилсан ярилцлагын аргаар явуулж, үр дүнг ижил төстэй хариултыг нэгтгэх, дүгнэх байдлаар боловсруулалт хийсэн. АШУҮИС-ын судалгааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрөл авсан хурлын тэмдэглэл дугаар 2020/3-209.

Судалгаанд хамруулах шалгуур:

- Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/185 тоот тушаал Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос шалтгаалсан гэмтлийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалын дагуу Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан буюу ажилтан үйлдвэрлэлийн ослын улмаас хүнд гэмтэл авч хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувь алдсан осолдогчийг сонгож судалгаанд хамруулсан.
- Судалгаанд оролцохыг зөвшөөрсөн байх
- Судалгаанд хамрагдсад нь үйлдвэрлэлийн ослын улмаас H54, S49, S68, S53, S72, S14, G56, H90, T23, T32 оношийн бүлэгт хамаарах

Үр дүн: Судалгаанд хамрагдсадын дундаж нас 47.8±2 жил байв. Харин осолд өртөх үеийн насны хувьд 43% нь 16-25 насандаа, 33% нь 26-35 насандаа, 17% нь 36-45 насандаа үйлдвэрлэлийн осолд өртсөн бөгөөд осолд өртөх үеийн дундаж нас 29.3 жил байв. Хүйсийн хувьд 24 нь эрэгтэй, 6 нь эмэгтэй байсан эдгээр хүмүүс бүгд УБ хотод амьдардаг иргэд байв. Хөдөлмөрийн чадвар алдалт (ХЧА) жил дунджаар 18.2 жил байв. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 17% нь барилгын салбарт ажиллаж байхдаа осолд өртсөн бол 60% нь сохрох буюу хараа муудах эрүүл мэндийн хохирол учирсан бол 27%-н үйлдвэрлэлийн салбарт тэдгээрийн 75% нь мөчдийн тайралт оноштой, 17% нь геологи, газрын тос, уурхайн салбарт ажиллаж байсан бөгөөд тэдгээрийн 60% нь мөчдийн тайралт оноштой, мөн 17% нь эрчим хүчний салбарт тэдгээрийн 40% нь ямар нэг түлэгдэлт оноштой байна.

Харах ба сонсох эрхтнээ хагас ба бүрэн алдсан хүмүүс**:** Судалгаанд хамрагдсадын дундаж нас 47.5, хүйсийн хувьд 11 нь эрэгтэй, 2 эмэгтэй байсан бүгд УБ хотод амьдардаг байна. ХЧА жил дунджаар 19 жил .ОУ-ын өвчний Х ангиллаар үйлдвэрлэлийн ослын улмаас үүссэн гэмтлийг судалгаанд хамрагдсадын бүлэглэн харуулбал:

1. Сохор ба хараа муудах - H54 (n=12)
   - Нэг нүд нь хэвийн хараатай нөгөө нүдний харах чадал 0.05 буюу түүнээс доош – ХЧА -50-69% n=6
   - Хоёр нүдний сайн харж байгаа нүд нь зохих эмчилгээний дараа таарсан шилтэйгээ харах чадал 0.3-0.1 боловч харараны талбайн алдагдалтай ХЧА 70-79% n=3
   - Хоёр нүдний хараа зохих эмчилгээний дараа, таарсан шилтэйгээ харах чадал 0,05 буюу түүнээс доош (2.5 метр зайд гарын хуруу тоолох төдий) ХЧА 90-100% n=1
2. Сонсгол алдах H90 (n=1)
   - H90.7 – Нэг чихний сонсгол хэвийн, өрөөсөн чихний дуу дамжуулах ба хүлээн авах холимог хэлбэрийн сонсгол бууралт – ХЧА - 70%

Судалгаанд хамрагдсадын дундаж нас 48.6±2 жил харин осолд өртөх үеийн дундаж нас 29±3 жил тус тус байсан. Осолд өртөх үед ажиллаж байсан салбарын хувьд авч үзэхэд тээвэр, төмөр зам 27.3%, барилга 27.3%, боловсруулах үйлдвэр 18.1%, бусад 27.3% байна. Үйлдвэрлэлийн осол өртсөний дараа 67% ажилгүй, 17% мал маллах, газар тариалан эрхлэх, 16% нь түгээгч, жолооч зэрэг ажил эрхэлж байна. Осолд өртсөн шалтгааны хувьд хувийн хамгаалах хэрэгсэлгүй ажил хийснээс нүд рүүгээ төмрийн үртэс, хатуу биет бусад зүйлсийг оруулсан 50%, химийн бодист өртсөн16%, дарагдах, цохигдсон өндрөөс унасан, ажлын байрны маргаанаас үүдсэн зэрэг шалтгаанууд

үлдсан хувийг эзэлж байна.

Үйлдвэрлэлийн ослын улмаас хувь хүнд учирсан эдийн засгийн дарамтыг судлахад улсаас сард авч буй тэтгэмж дунджаар 491000 төгрөг байгаа ба осолд өртөх үеийн цалингаас хамаарч ялгаатай байна. Ослын дараа байгууллагаас өгсөн нөхөн төлбөр хангалтгүй, эмчилгээний зардлыг нэг удаа байгууллагаас гаргасан гэж ихэнх оролцогчид хариулсан. Харин цаашид гарах зардлууд болох өдөр бүр хэрэглэдэг өвчин намдаах, нойрны, зүрхний болон бусад эм тарианы зардал (сард дунджаар 78000 төгрөг), эмчилгээний зардал (дунджаар 2,5 сая), өмгөөлөгчийн зардал (дунджаар 3 сая), сувилал бариа заслын зардал (дунджаар 500000 төгрөг) зэрэг зардлуудыг хувь хүн гаргасан байна. Эдгээр зардлуудыг гаргахдаа ихэнх нь гэрийн хамаг юмаа зарсан, ах дүү хамаатан садан, найз нөхдөөсөө гуйсан байв. Осолд орохын өмнөх таны орлого таны амьдралд хүрэлцээтэй байсан уу? гэсэн асуултанд бүх оролцогчид тийм гэж хариулсан ба одоогийн таны орлого болон үйлдвэрлэлийн ослын тэтгэмж таны амьдралд чинь хүрэлцээтэй юу? гэсэн асуултанд 92% нь хүрэлцээгүй, маш хангалтгүй гэж хариулж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс орлого буурсан, хөдөлмөрийн чадвартаа тохирсон ажил эрхлэх боломж, нөхцөл бүрдээгүй, одоогийн орлого нь хүрэлцээгүй амьдарч байна гэж ихэнх оролцогчид хариулсан.

Мөчдийн тайрагдах, хугарах, мэдрэл гэмтсэний улмаас хөдөлмөрийн чадвараа хагас ба бүрэн алдсан хүмүүс**:** Судалгаанд хамрагдсадын дундаж нас 48 жил, хүйсийн хувьд эмэгтэй нь 4, эрэгтэй нь 13 байсан бөгөөд бүгд УБ хотод амьдардаг байна. ХЧА жил дунджаар 17 жил байв.ОУ-ын өвчний Х ангиллаар үйлдвэрлэлийн ослын улмаас үүссэн гэмтлийг судалгаанд хамрагдсадын бүлэглэн харуулбал:

1. Мөчид тайрагдах-S49 (бугуй), S68 (гар), S68.2(хуруу) (n=5)
2. Мэдрэл гэмтэл-S14(хүзүү), S53 (тохойн үе), G56 (дээд мөч) (n=4)
3. Хугарал-S02 (нүүрний яс), S72 (дунд чөмөг) (n=3)
4. Химийн ба халууны үйлчлэл-T23, T32 (n=2)

Нийт осолд өртөгсдийн 29.4% нь ямар нэг үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаад өртсөн бөгөөд тэдгээрийн 60% нь мөч тайралт гэсэн оноштой, мөн хувь нь эрчим хүчний салбарт ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осолд өртсөн бөгөөд тэдгээрийн 40% нь халууны үйлчлэлд өртөж түлэгдсэн, уул уурхай геологийн салбарт ажиллаж байсан хүмүүсийн 60% нь ямар нэг хугарал оноштой байна. Судалгаанд оролцогчдын 59% нь ажиллаж байсан машин тоног төхөөрөмж нь гацсан, эвдэрсэн, буруу ажиллуулсан, цэвэрлэж байхад нь ажиллуулсан зэрэг шалтгаанаас, 17% нь хүчдэлд цохиулсан, 12% нь ямар нэг зүйлд дарагдсан цохиулсан, 6% нь өндрөөс унасан байна. Машин механизм тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа алдагдсанаас гар, сарвуу, хуруу тайрагдах тохиолдлууд ихэнхдээ гарч байгаа бөгөөд эдгээр хүмүүст олон удаагийн хагалгаа хийснээс наркозонд олон удаа орох юм мартах, тайрагдсан гар хуруу таталдах, өвдөх, юм барьж, ажил хийх боломжгүй байдаг, гадуу явахдаа ичих гадуурхагддаг гэж хариулсан байна. Удирдлагаас осолд өртсний дараа хэнд ч ямар ч дэмжлэг үзүүлээгүй байна. Ихэнх тохиолдолд аав, ээж хамаатан, ах дүүгээсээ гуйсан, хамаг өнгөтэй өөдтэй юмаа зарсан, дүү нар сурах боломжгүй болсон гэжээ. Одоогийн ажил эрхлэлтийн байдал манаач, тамхи зардаг, малчин гэсэн бол дийлэнх нь ажил эрхэлдэггүй, ажилд авдаггүй гэж хариулсан байна.

Үйлдвэрлэлийн осолд орохоос өмнөх үеийн цалин оноосоо хамаарч өөр байгаа боловч одоогийн орлого нь 2-3 дахин буурсан байдал ажиглагдаж байна. Тухайн үеийн цалин амьдрал хүрэлцээтэй байсан эсэх асуултанд 88% нь тийм гэж хариулсан байна. 5 тохиолдолд үндсэн ажлаасаа гадуур ажил хийж нэмэлт орлого олдог байсан боловч одоо боломжгүй болж орлого нь буурсан байна. Сарын дундаж тэтгэмж 561000 төгрөг байна. Одоогийн өрхийн орлого 500,000-800,000 төгрөг байна голдуу ХЧА-ын тэтгэмжээрээ амьдардаг байна.Сард эрүүл мэндийн үйлчилгээ, эм тарианд дунджаар 80.000-120.000 ын хооронд зарцуулж байна. 100% Амьдрал дордсон нийгмийн статус хамгийн муу түвшинд очсон гэж хариулсан. Эрүүл мэндийн байдал ослын шалтгаанаас үүдэж 60% нь дордсон гэж хариулсан байна. Янгинаж өвддөг, гэмтэлтэй хэсэг даарч хөрдөг 3 тохиолдол, элэгний С вирустай болсон, хурдан хөдөлж чаддаггүй, өтгөн гарахгүй 2 хоногт 1 удаа бургуй хийдэг, шээс гарахгүй тамсол уудаг. 1 таягтай явдаг. 2 хөл саажилттай, зүрх өвдөнө, даралт ихсэнэ. Ослын улмаас нөгөө тал харвасан, чихрийн шижинтэй болсон.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахтай холбоотой бэрхшээлийг асуухад эмнэлэг ачаалал ихтэй, цаг авахаар маш удаж байж үзүүлдэг. Нэг очсон өдрөө үзүүлэх боломжгүй байдаг тул хүндрэлтэй гэж хариулжээ. Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэлийн осолд өртсөн хүмүүсийн сэтгэл санааны байдал гунигласан, гутарсан, амьдралдаа сэтгэл хангалуун биш гэж хариулах нь 80-90%-тай байсан байсан. Хамт олны харилцаа өөрчлөгдсөн эсэх хариултанд 90% хамт олонгүй болсон тэд хөндийрсөн гэж хариулсан бол байгууллагын удирдах ажилтны харилцаанд орсон өөрчлөлт гэсэн асуултанд огт харьцдаггүй гэж бүгд хариулсан.

Хэлцэмж: 2013 онд БНСУ-д гарсан үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлын зардлыг Солонгосын 4 дэх удаагийн хөдөлмөрийн нөхцлийн судалгаанд үндэслэн тооцсон. Алдагдлын нийт зардал 27.224 сая ам.доллараар хэмжигдэж байгаа бөгөөд хамгийн их хохирол амссан нь 79.5% нь хувь хүмүүс, 20.4% нь ажил олгогчид, 0.1% нь засгийн газар байдаг гэж гаргажээ. Эдгээр зардал нь 2013 онд Өмнөд Солонгосын дотоодын нийт бүтээгдэхүүний 2.1% тай тэнцэж байна. Үйлдвэрлэлийн ослын улмаас нийгэмд учруулсан хохирол/нас барсан нь 640.000 ам.доллар; ≤3 хоног ажилгүй хүн 7000 доллар, ≥4 хоног ажилгүй 242 мянган ам.доллар байсан байна[7]. Судалгааны ажлын хүрээнд үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан хүмүүсийн 2017-2021 онуудад үйлдвэрлэлийн ослоос үүдэлтэй сэргийлж болох амьдралын алдсан жилийг тооцож, дундаж цалинтай харьцуулж үзэхэд

83.245.680.000 төгрөгний эдийн засгийн алдагдал үүссэн байгаа бөгөөд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний 0.1% ыг эзэлж байгаа нь Солонгос улсын тохиолдлоос бага байгаа боловч хүн амын тоонд харьцуулбал өндөр үзүүлэлт байв. Ажилгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ямар шалтгаанаар ажилд орж чадахгүй байгаа, ажил хийхэд гол хүндрэл бэрхшээлийг тодруулахад тэдний 22.9% нь гадаад төрх, бие бялдрын хөгжил, 20% нь ажлын туршлагагүй, 18.6% нь ажлын ачаалал их зэрэг нь хүндрэлтэй байдаг хэмээн хариулсан[8]. Манай судалгаанд хамрагдсан 30 хүний 80% орчим нь ажилд авахдаа гадаад төрх хардаг, ажлын ачаалал их зэрэг нь хүндрэлтэй байдаг хэмээн хариулсан нь уг судалгааны үр дүнтэй ижил буюу хөгжлийн бэрхшээлтэй болсон осолдогчид ажилд ороход хүндрэлтэй байдаг байна. Mohammad Aghaali, Seyed Davood Mirtorabi нарын судалгаа нь Иран улс дахь үйлдвэрлэлийн ослын улмаас нас баралт, тэдгээрийн амьдралын алдсан жилүүдийг тооцох зорилготой байсан.

Уг судалгаанд 2012-2016 оны хооронд үйлдвэрлэлийн ослоор 8606 хүн нас барсан буюу жилд 1000 ажилчинд 3.99 нас баралт тохиолдож нийт алдсан жил 433,251 хүн жил байна. Үйлдвэрлэлийн ослоор нас барсан хүмүүсийн 98.7 хувь нь эрэгтэйчүүдэд тохиолдсон байна[9]. Манай судалгаанд хамрагдсан 30 осолдогчийн 80% нь эрэгтэй байсан нь уг судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Сүүлийн 5 жилийн Монгол улсад тохиолдсон үйлдвэрлэлийн ослын улмаар нас барсан тохиолдлуудын амьдралын алдсан жилийг тооцож үзэхэд 6225 жил буюу 100,000 хүн тутамд 7.6 хүн нас барсан байна. Үндэсний статистикийн хорооны тооцооллоор 2021 оны өрхийн дундаж орлого 1.621.454 төгрөг байгаа бол судалгаанд хамрагдсан үйлдвэрлэлийн осолд өртсөн хүмүүсийн 90.1% нь өрхийн дундаж орлого 500.000-800.000 төгрөг байгаа нь улсын дунджаас доогуур өрхийн сарын орлоготой байна[10]. Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар хүн амын амьжиргааны доод түвшин гэж“ хүн амын хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээ гэж тодорхойлсон. Үндэсний статистикийн хорооны 2021-2022 оны “Хүн амын амьжиргааны доод түвшин, нэг хүнд сард ногдохоор” 277.800 төгрөг гэж тооцоолсон байна.

Судалгаанд хамрагдсан осолдогчдын сарын дундаж орлого буюу тэтгэмж 491.000 төгрөг байгаа бөгөөд сар бүр эм, тариа эмчилгээнд дунджаар 80.000-120.000 төгрөг зарцуулж байна. Эндээс харахад судалгаанд хамрагдсан үйлдвэрлэлийн осолд өртөгдсөд хүн амын амжиргааны доод түвшинд байна[11]. Hedieh Chorom нарын 2008-2011 онд Тегеран дахь үйлдвэрлэлийн ослын дарамт сэдэвтэй судалгаа нь нийгмийн даатгалын мэдээлэлд үндэслэж үйлдвэрлэлийн ослоор дутуу нас баралтын улмаас алдсан жилийг тооцох болон хөдөлмөрийн чадвараа алдсанаас үүссэн дарамтыг судлах зорилготой. ХЧА-н түвшин 399.552 жил байв[12]. 25-34 насны хооронд үйлдвэрлэлийн осолд өртөлт хамгийн өндөр Хүйсийн хувьд 99% эрэгтэй ажилчид байсан. Хамгийн түгээмэл тохиолддог осол нь гэмтэл, хугарал юм. Нийт нас баралт болон ХЧА-ын амьдралын алдсан жил 119,609 жил байв. Осолд өртөх үеийн насны хувьд хөдөлмөрийн насны буюу байгаа бөгөөд 43% нь 16-25 насандаа, 33% нь 26-35 насандаа, 17% нь 36-45 насандаа үйлдвэрлэлийн осолд өртсөн бөгөөд осолд өртөх үеийн дундаж нас 29.3 нас байгаа нь Тегеран дахь үйлдвэрлэлийн ослын дарамт судалгааны үр дүнтэй ойролцоо байна. Amati. C нарын (2006) Сэтгэл зүйн эмгэг, стресс, аюулгүй байдлын хоорондын уялдаа холбоог судласан судалгааны дүнд ажилтай холбоотой осол, эрүүл мэндийн хохирол нь тухайн осол болон өвчлөлд өртсөн хувь хүмүүс болон тэдний гэр бүлд хүчтэй нөлөө үзүүлдэг, мөн олон хүний ажил хөдөлмөр эрхлэх боломжид нөлөөлдөг байна гэж үзсэн байна[13]. Судалгаанд хамрагдсан 30 хүний 80% нь сэтгэл гутралтай, 70% нь ажил эрхлэх боломжгүй байгаа нь дээр дурьдсан судалгаатай нийцэж байна.

Дүгнэлт: Үйлдвэрлэлийн осол нь зөвхөн эдийн засагт хохирол учруулаад зогсохгүй ажилтны хувийн амьдрал, эрүүл мэндэд нөлөөлөхүйц хохирол учруулж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн осол өртсөн хүмүүс хөдөлмөрийн чадвартаа тохирсон ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй, орлогогүй болоод зогсохгүй, хамт олон, гэр бүл, нийгэмд гадуурхагдаж сэтгэл зүйн маш их хохирол амсаж байна.

Санал зөвлөмж: Үйлдвэрлэлийн ослыг урьдчилан сэргийлэх, ажилчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ХАБЭА-н менежментийн тогтолцоог сайжруулах, ажилчдын ХАБЭА-н ойлголт мэдлэг, хандлагыг сайжруулах, салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг хөрсөн дээр буулгахад бүх талууд анхаарч оролцох шаардлагатай байна.

Ном зүй:

1. *МХААЭАМХ ТББ, Сертификат III ХАБЭА гарын авлага. УБ. (2017) х63-66*
2. *Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, SICA, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл судалгааны тайлан. УБ. (2020) х7*
3. *Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институц. Үйлдвэрлэлийн осол хурц хордлогын шинжилгээ судалгааны тайлан УБ. (2020) х9*
4. *Б.Цэнд, М. Д. “Улаанбаатар хотын Сонгионохайрхан дүүргийн хүн амын дундах гэмтэл, согогийн өвчний шалтгаант хөдөлмөрийн чадвар алдалтыг судалсан дүн судалгааны тайлан.”Нийгмийн эрүүл мэндийн эрин сэтгүүл (2018). №12 УБ. Х143*
5. *Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, SICA. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нийгэм, эдийн засгийн нөлөөлөл судалгааны тайлан УБ.(2020) х10*
6. *МХЕГ. Үйлвэрлэлийн осол хурц хордлогын нэгдсэн мэдээлллийн систем www.om.inspection.mn. (2022) 2022.05.25*
7. *Kim, K. W. Costs of injuries and ill health in the workplace in South Korea. (2018). Journal of Int J Occup Saf Ergon 2020 Dec 26(4):p772-779.*
8. *ХНХЯ, ХНСИ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан (2022). Х63*
9. *Mohammad Aghaali, 1, 4 Seyed Davood Mirtorabi, 2 Mohammad Reza Ghadirzadeh, 3 and Seyed Saeed Hashemi-Nazari 4 (2019).*

Mortality and Years of Life Lost Due to Occupational Injury in Iran (2012-2016) Journal of Research in Health Sciences 2019 Spring; 19(2): e00444.Published online 2019 Jun 1.

10. *Үндэсний статистикийн хороо Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. "Монгол улсын өрхийн дундаж орлого" https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_1900_001V1 2022.05.20*
11. *Үндэсний статистикийн хороо Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. "Хүн амын амьжиргааны доод түвшин, нэг хүнд сард ногдохоор" 2022 2022.05.20 https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1900_010V1&AIMAG_select_all=0&AIMAGSingleSelect=_5&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2022&viewtype=table*
12. *Hedieh Chorom Mohammad Hossein Taghdisi Parvin Nassiri Burden of Occupational Accidents in Tehran during 2008-2011 Iran J Health Sci. 2014; 2 (2) :p45-51*
13. *Amati. C., A., and Scaife R) Investigation of the Links between Psychological IllHealth, Stress and Safety. Research Report 488. Prepared by The Keil Centre for theHealth and Safety Executive. Retrievable at; (2006) p33 http://www.hse.gov.uk/RESEARCH/rrhtm/index.htm*

The health and economic pressure of who affected by workplace accidents

Maral S[1,2], Myagmarchuluun S[2], Gantugs YU[2]

[1]Department of Environmental and Occupational Health, School of public health, MNUMS
[2]OSH Training center and management consulting OSHMI
E-mail: marals0716@gmail.com, Tel: 99198589

Background: Interviews with a total of 30 people who lost one or both eyes as a result of an industrial accident, lost 0.05 or less eyesight, had a limb amputation, or had a 50%-100% rate of disability due to a neurological disorder.
Aim: To study the health and economic pressures of individuals who have lost their ability to work due to an industrial accident.
Materials and Methods: The study was conducted using qualitative research methods and was classified as International Disease Classification H54,S49, S68, S68.2, S53, S72, S14,G56, H90, T23, T32, S02 with a total of 30 people were conducted.
Results: The mean age of the participants was 47.8±2. In terms of age at the time of the accident, 43% were between the ages of 16-25, 33% between the ages of 26-35 and 17% between the ages of 36-45, and the average age at the time of the accident was 29.3 years. The cause of the accident was 63.6% due to lack of personal protective equipment or lack of face protection, and 36.4% due to lack of workplace safety management. Wages in the pre-accident period vary from year to year, but current incomes have fallen by a factor of two to three. The average monthly allowance is MNT 561,000 mostly living on allowances. On average, they spend between 80,000 and 120,000 MNT per month on health care and medicines. 100% responded that the deteriorating social status of life has reached the worst level. 60% of respondents said that their health condition had deteriorated due to the accident.
Conclusion: All parties need to be responsible for occupational safety, as industrial accidents not only cause economic damage but also irreparable damage to workers' personal lives and health.

Keywords: Workplace accident, Occupational safety and health, disability, years of life lost